



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/856

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.12, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны “Аймгийн 2021 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 4/03 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 1/1315 албан бичигийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотод нийтийн тээврийн хэрэгслийн цахим картаар үнэ төлбөргүй зорчсон аймгийн харъяат ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн олговорт 2 021 500.00 төгрөг /хоёр сая хорин нэгэн мянга таван зуун/-ийг үйлчилгээний байгууллагуудаас ирүүлсэн нэхэмжлэлийг үндэслэн зарцуулсугай.

2. Нөхөн олговорт зарцуулах 2 021 500.00 төгрөгийг аймгийн Засаг дарга дансанд 2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

